



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/175

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор түймэр унтраах багаж хэрэгсэл (100 ширхэг үүргэвчин гал унтраагуур) нийлүүлэх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга:

Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Г.Бямбажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

М.Алтанцэцэг (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл:

Б.Туяа (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга:

А.Гэрэл (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл) д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

